

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

2022 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 24-НИЙ ӨДРИЙН НИЙСЛЭЛИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН ЭЭЛЖИТ
/ЦАХИМ/ ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨН ДЭЭР НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧААС
ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТ

2022 оны 02 дугаар сарын 01

Улаанбаатар хот

Д/д	Үүрэг, даалгаврын дагуу хийж, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	Үүрэг, даалгавар биелүүлээгүй шалтгаан	Цаашид авч хэрэгжүүлэх арга зам	Оноо
Үүрэг, даалгавар-НЭГ: 2022 онд Улс, нийслэлийн төсөв, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх ажлуудын бэлтгэлийг сайтар хангах. Үүнд: - Энэ сардаа багтаан эрх шилжүүлж дуусгах. - Худалдан авах ажиллагааг ил тод нээлттэй зохион байгуулах.				
1.	Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт 2022 оны Улс, Нийслэл, дүүрэг, дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих нийт 170 төсөл, арга хэмжээ батлагдсан. Үүнээс дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2022 онд шинээр хэрэгжих 19, 2021-2022 он дамжин хэрэгжих 16 төсөл, арга хэмжээний бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Дүүрэг, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх төсөл арга хэмжээний техникийн тодорхойлолт, ажлын даалгаврыг 2022 оны 02 дугаар сарын 01-ний өдөр Дүүргийн Худалдан авах ажиллагааны албанд хүргүүлэх талаарх мэдэгдлийг 2022 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 3/101 тоот албан бичгээр холбогдох хэлтэс албадад хүргүүлэн ажилласан.	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	50
Үүрэг, даалгавар ХОЁР: Нутгийн захиргааны байгууллагууд дотоодоо халдвараас урьдчилан сэргийлж, ариутгал, халдваргүйжүүлэлтийн ажлыг тогтмол хийж, халдвар илэрсэн үед авах хариу арга хэмжээний түр заавар зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах.				
2.	Засаг даргын Тамгын газрын байранд өөрсдийн нөөц бололцоогоор өдөрт 3 удаа ариутгал халдваргүйтгэл хийж гүйцэтгэсэн. Мөн 2022 оны 01 дүгээр сарын 27, 28-ны өдрүүдэд 1-5 давхрын өрөө тасалгаа, коридор, шат, хогийн сав зэрэг нийт 1260 м.кв талбайд клорсепт 17 бодисын 0.05%-ийн уусмалаар урьдчилан сэргийлэх халдваргүйтгэл хийлгэсэн. Халдвараас урьдчилан сэргийлэх зөвлөмжийг мөрдөн ажиллаж шинж тэмдэг илэрсэн ажилтан албан хаагчдыг ажлын байранд нэвтрүүлэхгүйгээр түргэвчилсэн тестээр шинжилгээ авч эерэг гарсан тохиолдолд харьяа өрхийн эмнэлэг рүү цаг алдалгүй шилжүүлэн ажиллаж байна.	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	100
Үүрэг, даалгавар ГУРАВ: Нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудын халдвар хамгаалалтын дэглэмийг сайтар мөрдүүлж, ариутгал, халдваргүйжилтийг хийлгэж, арга зүйн зөвлөн туслах ажлуудыг сайтар зохион байгуулах.				

3.	<p>МХЕГ-ын даргын баталсан удирдамжийн дагуу Хэлт антисептик ХХК-ийн ариутгал халдваргүйжүүлэлтийн баг дүүргийн Засаг даргын Тамгын газрын 1-5 давхрын өрөө тасалгаа, коридор, шат, хогийн сав зэрэг нийт 1260 м.кв талбайд клорсепт 17 бодисын 0.05%-ийн уусмалаар урьдчилан сэргийлэх халдваргүйтгэл болон шавьжгүйтгэл хийхэд мөн Ариун сан нар ХХК-ий халдваргүйжүүлэлтийн баг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын 1-5 давхрын өрөөнүүд, коридор, ариун цэврийн өрөө, хогийн сав зэрэг нийт 2920 мкв талбайд 0.06%-ийн клорсептын уусмалаар мананцар үүсгэж голомтын эцсийн халдваргүйжүүлэлтийг хийхэд хяналт тавьж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.</p> <p>Тайлант хугацаанд аж ахуйн нэгж байгууллагуудын халдвар хамгааллын дэглэмийн мөрдөлтөд хяналт тавьж ажиллаагүй болно.</p>	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	30
<p>Үүрэг, даалгавар ДӨРӨВ: Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/22 дугаар захирамжаар 2022 оны нийслэлийн төсвийн орлогын хуваарийг батлагдсан, оны эхнээс төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг жигд ханган, орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх, бааз суурийг өргөтгөх, урьд оны дутуу төлөлтийг барагдуулах чиглэлээр тодорхой ажил зохион байгуулж ажиллах.</p>				
4.	<p>Дүүргийн Засаг даргын 2022 оны А/33 дугаар захирамжаар 2022 оны дүүргийн төсвийн орлогын сарын хуваарь батлагдсан. 2022 оны 01 дүгээр сард орон нутгаас нийслэлд 4 044,3 сая төгрөг төвлөрүүлж, төсвийн орлогын төлөвлөгөөгөөр 8 371,8 сая төгрөг төвлөрүүлнэ. Орлогын биелэлт урд оны төлөвлөснөөс давуулан биелүүлсэн ч орлогын бусад эх үүсвэрийг нэмэгдүүлэх чиглэлээр судалгаа хийн ажиллаж байна.</p>	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	70
<p>Үүрэг, даалгавар ТАВ: Инженер хангамжийн байгууллагууд инженерийн шугам сүлжээний аюулгүй байдлыг сайтар хангаж, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудыг хэрэглээний халуун, хүйтэн болон ундны ус, дулаан, цахилгаанаар тасалдалгүй хэвийн хангах, шуурхай бригадыг бэлэн байлгаж хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах.</p>				
5.	<p>Нийслэлийн удирдах ажилтнуудын 2021 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн ээлжит /цахим/ шуурхай зөвлөгөөн дээр Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчаас өгсөн үүрэг даалгаврын дагуу айл өрх, аж ахуйн нэгж байгууллагуудыг хэрэглээний халуун хүйтэн болон ундны ус, дулаан, цахилгаанаар тасалдалгүй хэвийн хангаж, шуурхай бригадын бэлэн байдалд анхаарч ажиллах тухай 2022 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн 2/19, 2/20 тоот албан бичгийг Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн Чингэлтэй хэрэглэгчдэд үйлчлэх төв, ОСНААУГ-ын хэрэглэгчдэд үйлчлэх төв - 6, 7-д хүргүүлж, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ болон шуурхай бригадын томилгоот бүрэлдэхүүний мэдээллийг 7 хоног бүрийн пүрэв гарагт тогтмол авч нэгтгэн хяналт тавин ажиллаж байна.</p>	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	100
<p>Үүрэг, даалгавар ЗУРГАА: Баярын өдрүүдэд ажиллах эргүүл, жижүүр томилон ажиллуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах.</p>				
6.	<p>Дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны “Сар шинийн баярын өдрүүдэд хариуцлагатай жижүүр томилон ажиллуулах тухай” А/16 дугаар тушаалаар Засаг даргын Тамгын газрын байранд баярын өдрүүдэд гарч болзошгүй аюул, ослоос урьдчилан сэргийлэх, шуурхай арга хэмжээ авч ажиллах үүрэг бүхий хариуцлагатай</p>	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	100


	жижүүрүүдийг 2022 оны 02 дугаар сарын 02-ны өдрөөс 2022 оны 02 дугаар сарын 06-ны өдрүүдэд томилон ажиллуулж, дүүргийн 1-19 дүгээр хорооны Засаг дарга нарт хороодын байранд үүрэг гүйцэтгэх хариуцлагатай эргүүл, жижүүр томилон ажиллуулахыг үүрэг болгон хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.			
Үүрэг, даалгавар ДОЛОО: Иргэд олон нийтийн амгалан тайван байдал, нийгмийн хэв журам, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, сэрэмжлүүлэх, аюулгүй байдлыг хангах, хяналт тавих ажлыг эрчимжүүлэн ажиллах.				
7.	<p>Иргэдийн угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх чиглэлээр 2022 оны 01 дүгээр сарын 19-ний өдрөөс 22-ны өдрүүдэд нийт 132 чиглэлд 08:00-11:00, 17:00-20:00 цагийн хооронд 2 ээлжээр дүүргийн гэр хорооллын бүсийн 13 хорооны 896 гудамжны 25347 айл өрх, аж ахуй нэгж байгууллагын 27 зуух, шахмал сайжруулсан түлш худалдан борлуулах 36 цэг, 459 тээврийн хэрэгсэлд үзлэг шалгалтыг хийж, айл өрх, аж ахуй нэгж, байгууллагыг угаарын хийн хордлогод өртөхөөс урьдчилан сэргийлэх, түүхий нүүрс болон зориулалтын бус утаа үүсгэгч материалыг галлагаанд хэрэглэхгүй байх чиглэлээр 67007 иргэнд яриа таниулга хийж ажиллахад түүхий нүүрс болон зориулалтын бус утаа үүсгэгч материалыг галлагаанд хэрэглэсэн зөрчил илрээгүй байна.</p> <p>“Сар шинэ-2022” ерөнхий арга хэмжээний хүрээнд өдөрт 42 чиглэлд 68 алба хаагч явган эргүүлийн үүрэг гүйцэтгэн иргэдэд Хулгайлах гэмт хэрэг, халаасны хулгайн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээлэл өгч хяналт тавьж ажиллаж байна. Мөн 2022 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр Цагдаагийн Ерөнхий газрын Хэвлэл мэдээллийн хэлтэстэй хамтран “Залилах”, “Хулгайлах” гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 3 удаа сэрэмжлүүлэг яриаг өгч ажилласан. Мөн “С1” телевизтэй хамтран хулгайлах төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сэрэмжлүүлэг мэдээ бэлтгэн, иргэд олон нийтэд мэдээлэл хүргэн ажиллаж байна.</p> <p>Томоохон зах худалдааны төв болох Алтжин, Содон, Юмт бөмбөгөр худалдааны төвүүдийн хамгаалалтын албатай хамтран 08:00-20:00 цаг хүртэл 4 чиглэлд явган эргүүлийн үүрэг гүйцэтгэхэд хулгайлах зөрчил нийт 10 илрүүлэн зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулан Зөрчлийн тухай хуулийн 8.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар шүүхээр 6 иргэнийг 7-30 хоног баривчлах, 1 иргэнийг 100000 төгрөгөөр торгож шийдвэрлэсэн байна.</p> <p>Цагдаагийн Ерөнхий газрын мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албатай хамтран дүүргийн 2, 3, 11 дүгээр хороо бөмбөгөр худалдааны төв, Хүчит шонхор зах, Улсын Их дэлгүүрийн гадна гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр зөөврийн хяналтын камер байршуулан халаасны хулгайн 1 зөрчлийг илрүүлэн зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явагдаж байна.</p> <p>Гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгуулахаар 6 аж ахуйн нэгж байгууллагад 6 төрлийн шаардлага, мэдэгдэл хүргүүлж, Удаа дараа зөрчил гаргасан “Аварга чоно” ХХК-ийн тайгер бааранд гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгуулах, шаардлага</p>	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	100

	<p>мэдэгдэл өгч үр дүнг тооцож Зөрчлийн тухай хуулийн 15.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар 2.500.000 төгрөгөөр торгож шийдвэрлэсэн.</p> <p>Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр: Тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр дүүргийн 6 лед дэлгэц, 1-19 дүгээр хороодын смарт дэлгэцэнд 4 төрлийн видео мэдээлэл, зах худалдааны төвүүдэд авто машины чанга яригч болон томоохон зах худалдааны төвүүдийн үзэлээр иргэдэд сэрэмжлүүлэг өгч ажилласан. Хулгайлах, залилах гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 24 төрлийн зурагт постер бэлтгэн хэлтсийн пэйж хуудсанд байршуулан иргэдэд сурталчилсан.</p>			
<p>Үүрэг, даалгавар НАЙМ: Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд өөрсдийнхөө ажилтан, албан хаагчдад байгууллагын үйлчилгээний соёл, ёс зүйг дээшлүүлэхэд анхаарах, мөн хөрөнгө орлогын мэдүүлгээ 02 дугаар сарын 10-ны дотор өгч дуусгах.</p>				
8.	<p>Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, сургаж хөгжүүлэх, төрийн албан хаагчдын ёс зүйн хэм хэмжээг мөрдүүлж, харилцаа хандлагыг сайжруулах зорилго бүхий "Мэдээллийн цаг" сургалтыг 2022 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр зохион байгуулж, нийт ажилтан, албан хаагчдыг хамруулсан.</p> <p>Дүүргийн Засаг даргын Тамгын газар, 1-19 дүгээр хороо, дэргэдэх хэлтэс албадын ХАСХОМ мэдүүлэх нийт 129 албан хаагч байгаа бөгөөд 2022 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар 50 хувьтай мэдүүлсэн байна. Нийт албан хаагчдад 2022 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн дотор мэдүүлэхийг анхааруулан ажиллаж байна.</p>	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	50
<p>Үүрэг, даалгавар ЕС: Дүүргийн хэмжээнд гамшиг ослоос урьдчилан сэргийлэх бэлтгэл ажлуудыг сайтар хангах.</p>				
9.	<p>Дүүргийн хэмжээнд болзошгүй гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, сургалт сурталчилгааг дүүргийн эрсдэл өндөр бүхий 7-19 дүгээр хороодын нутаг дэвсгэрт зохион байгуулан бэлтгэл бэлэн байдлыг ханган ажиллаж байна. 2022 оны 01 дүгээр сарын 27, 28-ны өдрүүдэд "Гал түймэр, угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх" нэгдсэн арга хэмжээг дүүргийн 11,12 дугаар хороонд зохион байгуулан ажилласан. Болзошгүй гамшиг ослоос урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээнд Гал түймрийн аюул, ахуйн осол, угаарын хий, объектын болзошгүй гал түймэр, гэр хорооллын айл өрхийн цахилгааны аюулгүй байдал, пийшин зуухны яндангийн бүрэн бүтэн байдал, зөв галлагааны талаар заавар, зөвлөмжөөр ханган зөрчил дутагдлыг арилгуулж тус хорооны нутаг дэвсгэрийн 702 айл өрхийн 996 иргэнд 1226 сэрэмжлүүлэг мэдээллийг хүргэн ажиллалаа.</p> <p>Мөн дүүргийн 16, 17, 18 дугаар хороодын нийт 64 иргэнд "Гал түймрийн аюул, галын аюулгүй байдлаас урьдчилан сэргийлэх, гамшигийн эрсдэлийг бууруулах арга хэмжээ, эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх сургалтуудыг танхим болон цахимаар дүүргийн Улаан загалмайн хороо, Дэлхийн зөн Олон улсын байгууллага, дүүргийн сайн дурын хэсэг, тус хороодын засаг даргын ажлын албатай хамтран нийт 4 удаа зохион байгуулсан.</p>	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	100

<p>Хаврын дулааралтын үед цас, мөс хайлж шар усны үер болох эрсдэлээс урьдчилан сэргийлж дүүргийн 17, 18, 19 дүгээр хороодын иргэд, олон нийтэд сэрэмжлүүлэг хүргэн нийт 248 ширхэг зөвлөмжийг тараан ажилласан.</p> <p>Уламжлалт Сар шинийн баярыг угтаж гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, мэдээ, мэдээлэл, заавар зөвлөмж, видео шторкийг бэлтгэж нийт 2 удаа хоолойн бичлэг хийлгэж, иргэд олон нийтэд 2 автомашины чанга яригчаар өдөрт 4-8 удаагийн давтамжтайгаар нийт 161 удаа хүргэж С1, MN25 дугаар суваг телевиз, MNC, Монголын үндэсний олон нийтийн телевизийн “Онцгой байдлын цаг” нэвтрүүлэгт тус тус сэрэмжлүүлэх мэдээ мэдээллийг 3 удаа хүргэсэн.</p> <p>Болзошгүй гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээний талаар мэдлэг мэдээллийг хүргэн хүн ам олноор цуглардаг худалдаа үйлчилгээний газрын танхимын чанга яригч, дүүргийн лед дэлгэц, MN Tower төвийн гадна талбайн лед дэлгэц, дүүргийн 1-19 дүгээр хорооны цахим дэлгэц, Алтжин бөмбөгөр худалдааны төвийн цахим дэлгэцээр тус бүр өдөрт 4-8 удаагийн давтамжтайгаар мэдээллийг шинэчлэн нийт 224 удаа явуулан цахим сайт болон олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нийт 2 удаагийн ярицлага, сонин хэвлэлд нийт 8 удаа мэдээллийг байршуулан ажиллаж байна.</p>			
--	--	--	--

ДАРГА

Н.БАТСҮМБЭРЭЛ



ТАНИЛЦСАН: НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

П.БАЯНБААТАР

ХЯНАСАН: ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Н.ХАНГАЙ

ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ ХАРИУЦСАН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

М.НАВЧАА

БИЕЛЭЛТ НЭГТГЭСЭН: ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

A handwritten signature in black ink, appearing to be the name 'Д. Долгормаа' (D. Dolgormaa), written in a cursive style.

Д.ДОЛГОРМАА